



“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

Компанийн тухай

- 04 Эрхэм зорилго
- 05 Бизнесийн үйл ажиллагааны чиглэл
- 06 Үйл ажиллагааны хураангуй

Компанийн засаглал

- 08 Төлөөлөн Удирдах Зөвлөл
- 09 Эрсдэл, дотоод аудит
- 10 БОНЗ
- 14 Оролцогч талуудын эрх ашиг
- 15 Мэдээллийн аюулгүй байдал



КОМПАНИЙН ТУХАЙ



МББСБХ-ны Зээлээс бусад үйлчилгээ
үзүүлэгч шилдэг байгууллага
2024



МББСБХ-ны Шилдэг валют
арилжааны байгууллага
2023



Монгол Улсын шилдэг мөнгөн
гуйвуулгын компани
2022



Эрхэм зорилго

Дэлхий даяар тархан суурьшсан Монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын бүх асуудалд хамгийн хямд бөгөөд хамгийн хурдан шийдлийг санал болгоно.



Алсын хараа

Монгол улсын үсрэнгүй хөгжилд хувь нэмрээ оруулсан олон улсын түвшинд өрсөлдөхүйц мөнгөн гуйвуулгын компани байна.



Эрхэмлэх үнэт зүйлс

Үр дүн, Хариуцлага, Багийн ажиллагаа, Ил тод байдал



Бизнесийн үйл ажиллагааны чиглэл

Мөнгөн гуйвуулга

SendMN гар утасны апп ашиглан дэлхийн 170 гаруй орон руу шилжүүлэг хийх боломжтой.

Зээл

Бид хэрэглээний, бизнесийн, барьцаагүй (дижитал) гэсэн 3 төрлийн зээлийн бүтээгдэхүүн санал болгож байна.

Төлбөр тооцоо

Нэхэмжлэлтэй ба нэхэмжлэлгүй дотоодын төлбөр тооцоог SendMN апп-р хийх боломжтой.



Валют арилжаа

Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудал болон 8 шаргад валют арилжааны салбартай. SendMN апп-р дамжуулан валютаа урьдчилан захиалж, онгоцонд суухаасаа өмнө салбараас очер дараалалгүй авах үйлчилгээг нэвтрүүлсэн.

Итгэлцэл

Доллар болон төгрөгийн итгэлцлийг SendMN апп-р дамжуулан хөрөнгө оруулагч, харилцагч нартаа өндөр өгөөжтэй санхүүгийн бүтээгдэхүүнийг санал болгож байна.

Нээлттэй ББСБ

Мөнгөн гуйвуулга болон валют арилжааны системийн боломжийг нээлттэйгээр бусад санхүүгийн байгууллагуудад санал болгодог.

Үйл ажиллагааны хураангуй

2024 онд бид:

Нийт гуйвуулга
/тэрбум төгрөг/
961.9

Нийт татан төвлөрүүлсэн
хөрөнгө
/тэрбум төгрөг/
2

Зээлийн багц
/тэрбум төгрөг/
7.23

Валют арилжаа
/тэрбум төгрөг/
75.5

- MAБМТ-ны ISO/IEC 27001:2013 стандартын магадлах аудитад орж стандартын шаардлагуудыг ханган гэрчилгээ авав
- АНУ-д Money 20/20 финтек арга хэмжээ болон Сингапур улсын финтек саммитэд амжилттай оролцов
- Солонгос иргэд өөрийн улсын төлбөрийн хэтэвчээ ашиглан Монголд төлбөр тооцоо хийх боломжтой болсон. Энэхүү үйлчилгээгээрээ бид ББСБ-ын холбооны “Алтан Од” хүндэтгэлийн арга хэмжээнээс “2024 оны зээлээс бусад үйлчилгээ үзүүлэгч шилдэг байгууллага” хүндэт цомыг гардан авсан
- Олон улсын бизнесийн гуйвуулгын үйл ажиллагаагаа өргөжүүлж Хятад улс руу бизнесийн гуйвуулга хийж эхэлсэн
- Харилцагч итгэлцлийн үйлчилгээг SendMN апп-аас цахимаар авах боломжтой болсон
- Барьцаагүй дижитал зээлийн үйлчилгээг SendMN апп-аас авах боломжтой болсон
- Монгол Банкнаас цахим мөнгө гаргах зөвшөөрөл, төлбөр тооцооны лиценз авав
- SendMN апп доторх бүтээгдэхүүн үйлчилгээг ашигласан харилцагчиддаа урамшууллын оноо бэлэглэдэг болсон



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



Төлөөлөн удирдах зөвлөл



Эрсдэл, дотоод аудит



БОНЗ



Оролцогч талуудын эрх ашиг

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Г.Болор-Эрдэнэ

ТУЗ-ийн дарга



Б.Төрболд

ТУЗ-ийн гишүүн



Т.Банзрагч

ТУЗ-ийн гишүүн



Ч.Доржнамжил

ТУЗ-ийн гишүүн



Г.Солонго

ТУЗ-ийн гишүүн



Н.Гантулга

ТУЗ-ийн гишүүн



С.Цэнгэл

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Ц.Ундрах

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Эрсдэл, дотоод аудит



2024 онд “Сэнд Эм Эн ББСБ” ХХК-ийн Дотоод аудит нь компанийн үйл ажиллагааны дотоод аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, зөвлөмж өгөх, зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авах, хяналт тавьж ажиллаж байна.




“Сэнд Эм Эн ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Дотоод аудитын асуудал хариуцсан ажилтныг нэгдсэн удирдлагаар ханган ажилладаг бөгөөд Дотоод алба болгон өргөжүүлэх зорилгоор 2024 онд компанийн Дотоод аудитын дүрэм, Дотоод аудитын албаны үйл ажиллагааны журам, Эрсдэлийн удирдлагын бодлого, Эрсдэлийн удирдлагын журмуудыг тус тус ТУЗ-ийн III улирлын ээлжит хурлаар батлуулав.


Эдгээр хууль зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах үүднээс компанийн нийт ажилтнуудад таниулах, дотоод аудит болон эрсдэлийн удирдлагын соёлыг компанидаа суулгах үүднээс холбогдох сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Нийгмийн хариуцлага


Нийт ажилтнуудын хүйсийн харьцаа



Дунд түвшний удирдлагын хүйсийн харьцаа



Шинэ ажилтнуудын хүйсийн харьцаа



“Сэнд Эм Эн ББСБ” ХХК нь жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн карьерын өсөлтийг дэмжих зорилготой ажилладаг. Тус компани хүүхэд асрах чөлөөтэй ажилтнууддаа хагас өдрийн болон зайнаас ажиллах боломжийг олгодог. Мөн 2025 онд Хүний нөөцийн бодлогын бичиг баримтад Жендерийн тэгш эрхийн бодлогыг тусгахаар төлөвлөж байна.

Эмэгтэй ажилтнуудад зориулсан “Менторшип” хөтөлбөр



“Эмэгтэйчүүдийн карьер өсөлт” сэдвээр танхим, цахим хосолсон менторын хөтөлбөрийг амжилттай зохион байгуулсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд эмэгтэй ажилтнууддаа хувь хүний хөгжилд анхаарах, хувийн амьдралаа хадгалан карьераа өсгөх боломж, туршлагаа солилцох арга хэмжээг зохион байгууллаа.

Залгамж халааны хөтөлбөр



Хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтнуудын хөгжлийг тасралтгүй хангах зорилгоор мөн ТУЗ-ийн Залгамж халааны бодлогын дагуу мэдлэг чадвар, туршлагаараа бусдыгаа түлхүүр ажилтнуудын ур чадвар, мэдлэгийг залгамжлуулан дараагийн түлхүүр ажилтныг бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд ажилтны мэргэжлийн ур чадварыг сайжруулах ажлуудыг хийснээр тухайн ажилтны ур чадварын үнэлгээ өмнөх жилээс өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Нийгмийн хариуцлага

Ажилтны сэтгэл ханамж

Бид ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хангах, өндөр сэтгэл ханамжийг хадгалах зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлсэн:

- ▶ 5 ба түүнээс дээш жил ажилласан ажилтанд сард нэг удаа цалинтай чөлөө авах эрх
- ▶ Хичээлийн шинэ жилээр эцэг, эхчүүдэд бүтэн өдрийн цалинтай чөлөө олгох
- ▶ Хүүхдийн баяраар нийт ажилтнуудын хүүхдүүдэд зориулсан хүүхдийн баярын арга хэмжээг оффист зохион байгуулах
- ▶ Хүүхдийн баяраар хүүхэдгүй ажилтнуудад хагас өдрийн чөлөө олгох
- ▶ 100 хувийн ирцтэй ажилласан ажилтандаа цалинтай чөлөө олгох
- ▶ Байгууллагын машиныг амралтын өдрөөр хотоос 100км радиуст ашиглах боломж




Мөн дотоод журамдаа **цалинтай чөлөө** олгох дараах нөхцлүүдийг тусгаж өгсөн:

- ▶ Ажилтан, ажилтны хүүхэд хурим хийвэл хотод ажлын 3 өдөр, орон нутагт ажлын 5 өдөр
- ▶ Ажил явдал гарсан тохиолдолд хотод ажлын 3 өдөр, орон нутагт ажлын 5 өдөр
- ▶ Шинэ аавын ажлын 10 хоног
- ▶ Сургуулийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа ажилтанд хагас өдөр
- ▶ Ажилтан, ажилтны хүүхэд өвдсөн тохиолдолд эмчийн магадлагааг нотолгоо болгон ажлын нэг хүртэлх өдөр
- ▶ Ажилтны төрсөн өдөр тохиож буй сарын аль нэг өдөр

Нийгмийн хариуцлага

Сургалт, хөгжил




■ Дотоод ■ Гадаад

2024 онд “Сэнд Эм Эн ББСБ” ХХК-ний ажилтнууд нийт 28 орчим сая төгрөгийг сургалт хөгжилд зориулан зарцуулсан ба гадаад болон дотоодын нийт 50 орчим сургалтад хамрагдсан байна. Эдгээр сургалтын 33 нь Мэргэжлийн үр чадварыг хөгжүүлэх сургалт, 17 нь Хувь хүний хөгжлийн сургалтууд байсан.

Анхан шатны тусламжийн сургалт 2024



Дотоод сургагч багшийн сургалт 2024



Нийгмийн хариуцлага



Бид “Veloо Foundation”-ын “Нарны Хүүхдүүд” төсөлд зориулсан Gobi Gallop Gala 2024 хандивын арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцон дэмжлээ. Тус арга хэмжээнээс цугласан хандив нь зорилтот бүлгийн 1000 гаруй хүүхдүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулагдах бөгөөд эхний ээлжинд хүүхдийн цэцэрлэг баригдсан.



“Ахиллис Хүүхэд” хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг спортоор хичээллүүлэх замаар ирээдүйн амьдралд итгэх итгэлийг нь нэмэгдүүлэх, идэвхтэй бүтээлч иргэн болоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой сургуульд суурилсан, биеийн тамирын хөтөлбөр юм. Манай компани тус хөтөлбөрт зориулан гүйлтийн пүүз болон дэмжлэг, урамшуулал олгон дэмжиж ажиллав.



Олон улсын мөнгөн гуйвуулгын финтек “Сэнд Эм Эн ББСБ” ХХК зүгээс Тулгар төрийн 2233 жил, Их Монгол Улсын 818 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Монгол үндэстэний бахархал Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан ИБУИНХУ-д оршин суугаа Монголчуудын хамгийн том баяр “Лондон Наадам - 2024” арга хэмжээг дэмжин ажиллав.



Манай компани Монгол Улс дахь Филиппин иргэдийн дунд зохион байгуулагдсан спортын арга хэмжээг хамтран зохион байгуулав.



2024 онд “SENDMN CUP” Монголын туялзуур сэлмийн холбооны “Б” зэрэглэлийн чансааны оноо олгох тэмцээн амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд 5 клубийн 70 гаруй сэлэмчид өрсөлдөв.

Оролцогч талуудын эрх ашиг



sendmn
мөнгөн гуйвуулга

Валютаа урьдчилж захиалаад

*1 сая ₮-с дээш валют захиалгад

Балгэнд
Travel Adapter

+ Adapter Case

7000 0909 f SendMN www.send.mn

Харилцагчийн үйлчилгээ

“Сэнд Эн Эм ББСБ” ХХК нь Харилцагчийн үйлчилгээний төвөөрөө дамжуулан харилцагчдын санал, хүсэлтийг утасны дуудлага, сошиал суваг болон 2 салбараар дамжуулан хүлээн авч шийдвэрлэхээс гадна шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл, заавар, зөвлөгөөг тогтмол хүргэж ажиллаж байна.

Компанийн Харилцагчийн үйлчилгээний төв нь 2024 онд нийт 85401 удаагийн харилцагчийн хандалт, хүсэлт, асуудлыг утасны дуудлага, сошиал суваг болон салбараар дамжуулан хүлээн авч, харилцагчдаас сошиал болон утасны дуудлагаар ирсэн санал, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн.

Харилцагчдын сэтгэл ханамжийн судалгааг 2024 онд нийтдээ 3 удаа авсан бөгөөд судалгааны үр дүнд суурилан бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, харилцагчийн санал, хүсэлтийг цаг алдалгүй хүлээн авах, харилцагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зэрэгт анхаарах холбогдох арга хэмжээ авч ажиллаа.



Ханган нийлүүлэгчтэй хамтын ажиллагаа

“Сэнд Эн Эм ББСБ” ХХК 2024 оны үйл ажиллагаа хэвийн явуулахад шаардлагатай ажил үйлчилгээ, бараа материалын хангамжийн хангах үүднээс ханган нийлүүлэгч нартай холбогдох гэрээнүүдийг байгуулсны үндсэн дээр хамтран ажиллав. Бараа, ажил үйлчилгээний чанар, эрсдэлийн түвшин, мөнгөн дүн, бизнесийн нэр хүнд, мэдээллийн аюулгүй байдлын баталгаа зэргийг харгалзан ханган нийлүүлэгчдийг сонгон ажилладаг.

Мэдээллийн аюулгүй байдал

CERTIFICATE OF REGISTRATION

IAS

ACCREDITED
Management Systems
Certification Body
MSCB-01

INTERNATIONAL
ASSOCIATION
OF CERTIFICATION BODIES
IAF



This Certificate has been awarded to

SendMN NBF LLC

Head office: - 7th floor, Central Park Tower, Amusement Park street, Chinggis Avenue-17,
1st khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar-14240, Mongolia

Branch 2:- Room 201, 2nd floor, Arga Bileg building, Naiman Sharga, Tumurchid street,
2nd khoroo, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia

Branch 4:- C/C 203-2, Passenger Terminal, 1st floor, Chinggis Khaan International airport,
4th bag, Sergelen Sum, Tuv Province, Mongolia

In recognition of the organization's Management System
which complies with

ISO/IEC 27001:2013

(Information Security Management System)

The scope of activities covered by this certificate is defined below

1. Loan Service
2. Currency exchange
3. Electronic payments and money transfers and remittance via mobile application
4. Trust service

SoA Details :- SM-NL-03- Dated-2024.15.03

SYNDICATE OF INTERNATIONAL SYSTEM CERTIFICATIONS

Certificate Number: **SIS8306231292**
Date of Initial Registration: **28.06.2023**
Latest Date of Issue: **29.06.2024**
Next surveillance due on: **28.05.2025**
Expiry Date: **27.06.2026**
Re-certification Due on: **28.05.2026**


Managing Director



Note: The certificate is the property of SIS Certifications & the Validity of the Certificate is subject to the successful completion of Surveillance Audit as or before the due date. (In case Surveillance Audit is not allowed to be conducted, this Certificate shall be suspended and must be returned immediately upon request.)

Certified Organization is responsible for maintaining the compliance of the relevant standard rules. Any significant changes in the scope of the certification or standard referred above render this certificate invalid

Corporate office: SIS Certifications Pvt. Ltd.
Unit No. 514, 5th Floor, Vipul Business Park, Sector-46, Sohna Road, Gurgaon-122016, Haryana, India.
International Subcontractor Key Locations: Qatar, Egypt, Italy, Canada & USA.
E-mail us - support@siscertifications.com, Call Whatsapp: +91-9943073391
The status of this certificate can be verified on <https://siscertifications.com>
Web - www.siscertifications.com



Issue No. - 02

Олон Улсын мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааг явуулдаг “Сэнд Эм Эн БСБ” ХХК нь банк, санхүүгийн салбар дах финтек компани юм. Харилцагч, хамтран ажиллагчид ба өөрийн компанийн мэдээллийн хөрөнгө болон кибер аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор мэдээллийн аюулгүй байдлын Олон Улсын стандарт “ISO/IEC 27001:2013”-ыг 2023 онд нэвтрүүлж хэрэгжүүлсэн бөгөөд 2024 онд магадлан аудит хийлгэж уг стандартын шаардлагуудыг ханган ажиллаж буйгаа нотлон “ISO/IEC 27001:2013” гэрчилгээг дахин авсан.

Ингэснээр манай компани нь Монгол Улсын банк, санхүүгийн салбарын мэдээллийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулахаас гадна банк, санхүүгийн салбарт итгэх гадаад, дотоодын харилцагч, хамтран ажиллагч, хөрөнгө оруулагчдын итгэлийг бататгаж байгаа явдал юм.

